ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/143/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.27 № 231

танай 2025.01.20-ны № 7-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
15 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ОТГОНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 5 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 98.0 хувьтай үнэлсэн байна.

011022047

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **134,963,961.30** | **120,306,570.96** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 85,839,895.70 | 86,016,458.61 |
| **354** | **Хангамжийн материал** | 49,124,065.60 | 34,290,112.35 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 49,124,065.60 | 34,290,112.35 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **855,194,486.93** | **829,440,704.13** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **855,194,486.93** | **829,440,704.13** |
| **392** | **Биет хөрөнгө** | 816,332,653.52 | 790,854,870.72 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 883,593,473.51 | 883,593,473.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (97,816,842.69) | (114,819,473.61) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,450,696.70 | 33,421,586.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (32,007,954.96) | (17,891,275.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,594,231.60 | 8,730,415.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,983,124.84) | (5,913,970.28) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,160,533.00 | 16,340,533.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (11,658,358.80) | (12,606,418.52) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 38,861,833.41 | 38,585,833.41 |
| 39301 | Програм хангамж | 1,380,000.00 | 1,380,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,098,166.59) | (1,374,166.59) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 38,580,000.00 | 38,580,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **990,158,448.23** | **949,747,275.09** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **990,158,448.23** | **949,747,275.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **990,158,448.23** | **949,747,275.09** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 38,580,000.00 | 38,580,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 38,580,000.00 | 38,580,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 951,045,722.72 | 910,634,549.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 925,287,093.99 | 951,045,722.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 25,758,628.73 | (40,411,173.14) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 532,725.51 | 532,725.51 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **990,158,448.23** | **949,747,275.09** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **608,954,275.00** | **808,181,454.55** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,859,275.00** | **2,956,154.55** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,859,275.00 | 2,956,154.55 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 300,000.00 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | | 300,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 12,119,100.40 | |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 4,740,174.60 | 2,656,154.55 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **592,095,000.00** | **805,225,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 565,913,000.00 | 783,943,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,182,000.00 | 21,282,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,182,000.00 | 21,282,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **583,195,646.27** | **848,592,627.69** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **583,195,646.27** | **848,592,627.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 572,286,154.19 | 839,525,672.22 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 396,130,158.18 | 599,776,831.09 |
| 210101 | Үндсэн цалин | 277,155,584.90 | 404,925,831.79 |
| 210102 | Нэмэгдэл | 103,966,751.28 | 167,480,106.30 |
| 210104 | Урамшуулал | 15,007,822.00 | 27,370,893.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,892,183.12 | 75,238,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,034,151.13 | 51,825,827.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,002,437.85 | 6,091,560.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,534,899.88 | 3,311,460.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 756,148.96 | 2,717,992.01 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,564,545.30 | 11,291,760.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,595,607.92 | 18,181,044.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,065,870.52 | 4,608,437.54 |
| 210302 | Түлш, халаалт | 8,424,091.40 | 6,854,925.99 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,105,646.00 | 6,717,681.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,120,256.40 | 20,344,907.80 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,120,256.40 | 20,344,907.80 |
| **2105** | **Нормативт зардал** | 61,144,774.00 | 72,613,950.00 |
| 210502 | Хоол, хүнс | 61,144,774.00 | 72,613,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 1,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 840,000.00 | 1,930,556.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 840,000.00 | 1,930,556.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,063,174.57 | 49,839,782.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,973,032.00 | 14,870,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,529,000.00 | 7,566,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25,561,142.57 | 27,403,782.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,909,492.08 | 9,066,955.47 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,823,100.00 | 7,566,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,823,100.00 | 7,566,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт** | 7,086,392.08 | 1,500,955.47 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,086,392.08 | 1,500,955.47 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **25,758,628.73** | **(40,411,173.14)** |
| | | **25,758,628.73** | **(40,411,173.14)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **25,758,628.73** | **(40,411,173.14)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **592,095,000.00** | **805,525,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **300,000.00** |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | | **300,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **592,095,000.00** | **805,225,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 565,913,000.00 | 783,943,300.00 |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,182,000.00 | 21,282,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,182,000.00 | 21,282,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **558,438,615.30** | **803,698,737.09** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **558,438,615.30** | **803,698,737.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 547,529,123.22 | 794,631,781.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 396,130,158.18 | 599,776,831.09 |
| 210101 | Үндсэн цалин | 277,155,584.90 | 404,925,831.79 |
| 210102 | Нэмэгдэл | 103,966,751.28 | 167,480,106.30 |
| 210103 | Урамшуулал | 15,007,822.00 | 27,370,893.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,892,183.12 | 75,238,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,034,151.13 | 51,825,827.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,002,437.85 | 6,091,560.42 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,534,899.88 | 3,311,460.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 756,148.96 | 2,717,992.01 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,564,545.30 | 11,291,760.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,595,607.92 | 18,181,044.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,065,870.52 | 4,608,437.54 |
| 210302 | Түлш, халаалт | 8,424,091.40 | 6,854,925.99 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,105,646.00 | 6,717,681.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 61,144,774.00 | 72,613,950.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол хүнс | 61,144,774.00 | 72,613,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 1,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 840,000.00 | 1,930,556.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 840,000.00 | 1,930,556.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,426,400.00 | 25,290,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,897,400.00 | 17,724,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,529,000.00 | 7,566,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,909,492.08 | 9,066,955.47 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,823,100.00 | 7,566,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,823,100.00 | 7,566,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7,086,392.08 | 1,500,955.47 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,086,392.08 | 1,500,955.47 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **33,656,384.70** | **1,826,562.91** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **1,650,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **33,656,384.70** | **176,562.91** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **52,183,511.00** | **85,839,895.70** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **85,839,895.70** | **86,016,458.61** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **38,580,000.00** | **532,725.51** | **951,045,722.72** | **990,158,448.23** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **38,580,000.00** | **532,725.51** | **951,045,722.72** | **990,158,448.23** |
| Тайлант үеийн үр дүн | | | (40,411,173.14) | (40,411,173.14) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **38,580,000.00** | **532,725.51** | **910,634,549.58** | **910,634,549.58** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | **85,839,895.70** | |
| **11100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | **85,839,895.70** | |
| **12** | **Татварын бус орлого** | **869,783,100.00** | **784,243,300.00** | **85,539,800.00** |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | | 300,000.00 | **(300,000.00)** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **869,783,100.00** | **784,066,737.09** | **85,716,362.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **869,783,100.00** | **784,066,737.09** | **85,716,362.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **869,783,100.00** | **784,066,737.09** | **85,716,362.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **869,783,100.00** | **784,066,737.09** | **85,716,362.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **869,783,100.00** | **784,066,737.09** | **85,716,362.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **668,825,000.00** | **599,776,831.09** | **69,048,168.91** |
| 210101 | Үндсэн цалин | 472,571,100.00 | 404,925,831.79 | 67,645,268.21 |
| 210102 | Нэмэгдэл | 184,220,000.00 | 167,480,106.30 | 16,739,893.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | |
| 210104 | Урамшуулал | 12,033,900.00 | 27,370,893.00 | (15,336,993.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **77,928,100.00** | **75,238,600.00** | **2,689,500.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,992,700.00 | 51,825,827.28 | 1,166,872.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,232,800.00 | 6,091,560.42 | 141,239.58 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,117,000.00 | 3,311,460.20 | (194,460.20) |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,117,000.00 | 2,717,992.01 | 399,007.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,468,600.00 | 11,291,760.09 | 1,176,839.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,282,000.00** | **19,781,044.53** | **1,500,955.47** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | **5,065,000.00** | **4,608,437.54** | **456,562.46** |
| 210302 | Түлш, халаалт | 8,624,200.00 | 6,854,925.99 | 1,769,274.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,992,800.00 | 6,717,681.00 | (724,881.00) |
| **2105** | **Нормативт зардал** | **81,807,100.00** | **72,613,950.00** | **9,193,150.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | | |
| 210502 | Хоол хүнс | 81,807,100.00 | 72,613,950.00 | 9,193,150.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,600,000.00 | 1,600,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 1,600,000.00 | 1,600,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,659,600.00** | **1,930,556.00** | **729,044.00** |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 2,659,600.00 | 1,930,556.00 | 729,044.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,997,300.00** | **26,940,800.00** | **4,056,500.00** |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,431,300.00 | 19,374,800.00 | 4,056,500.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,566,000.00 | 7,566,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,566,000.00 | 7,566,000.00 | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | **86,016,458.61** | |

### 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 12 | **Татварын бус орлого** | **21,282,000.00** | **21,282,000.00** | |
| **12200** | **Тусламжийн орлого** | **21,282,000.00** | **21,282,000.00** | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | **21,282,000.00** | **21,282,000.00** | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **21,282,000.00** | **21,282,000.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,282,000.00** | **19,781,044.53** | **1,500,955.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **21,282,000.00** | **19,781,044.53** | **1,500,955.47** |
| **2103** | **БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ** | **21,282,000.00** | **19,781,044.53** | **1,500,955.47** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | **5,065,000.00** | **4,608,437.54** | **456,562.46** |
| 21302 | Түлш халаалт | 8,624,200.00 | 6,854,925.99 | 1,769,274.01 |
| 21303 | Цэвэр, бохир ус | 5,992,800.00 | 6,717,681.00 | (724,881.00) |
| 210604 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,600,000.00 | 1,600,000.00 | |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | **1,500,955.47** | **(1,500,955.47)** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | **1,500,955.47** | **(1,500,955.47)** |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24.7 сая төгрөгийн зөрчил[1] илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв.

### 2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогчид 150 хувь, няравт 100.0 хувиар тооцон 3.2 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тендерээр худалдан авалтын 21.5 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн нь ТБОНӨХБАҮХА-ны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно, 48 дугаар зүйлийн 48.2.9-д Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 100.0 хувиар олгосон. | 1 | 3,248.5 | | | 1 | 3,248.5 | | | | | | |
| Тендерээр худалдан авалтын 21.5 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн | 1 | 21,479.6 | | | 1 | 21,479.6 | | | | | | |
| **Дүн** | **2** | **24,728.1** | | | **2** | **24,728.1** | | | | | | |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр | Дугаар 110/19125799 ДОА/2025/143/-НА-СТА-ТШЗ | Чойбалсан хот

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчид 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 3,248,500.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн *15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;* Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Отгонбаяр, нягтлан бодогч Д.Бямбаа нарт даалгав.

2125040314

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

2117144066
ХТҮ1037 9030891

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 109/19125799 ДОА-2025/143/НА-СТА-ТШЗ | Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах 21,479,600.00 төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ хууль тогтоомжийг мөрдөөгүй, холбогдох нотлох баримтыг хангалттай бүрдүүлээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх” зарчим, 48 дугаар зүйлийн 48.2.7-т “Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, 48.2.9-т “Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах”, 47.3-т “Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9 дэх *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол”*, 4.2.1.11 дэх *”хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу хийж, гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж байх , биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Отгонбаяр, нягтлан бодогч Д.Бямбаа нарт даалгав.

2125040320

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ